

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2023/157/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Аудитор: У.Ербол
Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	Error! Bookmark not defined.
Аудитын гол асуудал.....	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Б.ЕРХАНАТ ТАНАА

2023.02.13 № 51
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Шүүхийн Тамгын газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

Аудитын гол асуудал

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,565,662.00</u>	<u>8,292,902.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	7,565,662.00	8,292,902.00
354	Хангамжийн материал	7,565,662.00	8,292,902.00
35410	Бичиг хэргийн материал	44,000.00	44,000.00
35420	Аж ахуйн материал	5,264,700.00	5,152,700.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	219,240.00
35450	Барилгын засварын материал	-	620,000.00
35470	Бусад хангамжийн материал	2,256,962.00	2,256,962.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>378,443,897.27</u>	<u>377,716,424.82</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	378,443,897.27	377,716,424.82
392	Биет хөрөнгө	357,062,230.55	356,584,758.06
39201	Барилга, байгууламж, орон сууц	277,252,330.00	277,252,330.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(42,040,292.90)	(57,255,617.70)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	158,700,000.00	158,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(84,083,333.15)	(105,483,333.39)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	218,481,219.20	268,364,527.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	(181,601,264.37)	(196,854,069.77)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	101,799,894.00	106,875,894.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(91,806,854.23)	(95,678,004.64)
39217	Ном	360,532.00	663,032.00
393	Биет бус хөрөнгө	21,381,666.72	21,131,666.76
39301	Програм хангамж	1,550,000.00	1,550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(883,333.28)	(1,133,333.24)
39303	Бусад биет бус хөрөнгө	20,715,000.00	20,715,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>386,009,559.27</u>	<u>386,009,326.82</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>386,009,559.27</u>	<u>386,009,326.82</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	386,009,559.27	386,009,326.82
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	334,498,880.00	334,498,880.00
51101	Өмч: - төрийн	334,498,880.00	334,498,880.00
512	Хуримтлагдсан үр дүн	(181,034,784.37)	(181,035,016.82)
51210	Өмнөх үеийн үр дүн	(181,034,784.37)	(181,034,784.37)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(232.45)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	232,545,463.64	232,545,463.64
51600	Нөөцийн сан	-	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>386,009,559.27</u>	<u>386,009,326.82</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,254,267,943.00	1,553,601,934.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	75,839,043.00	56,121,178.36
120	Нийтлэг татварын бус орлого	75,839,043.00	56,121,178.36
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	75,839,043.00	56,121,178.36
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө		53,809,308.36
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа материал	75,839,043.00	2,311,870.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,178,428,900.00	1,497,480,756.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,178,428,900.00	1,496,340,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,178,428,900.00	1,496,340,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		- 1,139,856.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		- 1,139,856.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		- -
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,210,285,107.60	1,553,602,166.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,210,285,107.60	1,553,602,166.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,178,009,327.60	1,497,424,395.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	872,001,719.00	1,130,071,590.00
210101	Үндсэн цалин	699,645,428.00	768,455,622.00
210102	Нэмэгдэл	126,089,201.00	301,582,369.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,218,397.00	27,919,822.00
210104	Урамшуулал	16,048,693.00	32,113,777.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,839,583.00	148,698,886.49
210201	Тэтгэврийн даатгал	81,693,477.68	96,618,299.81
210202	Тэтгэмжийн даатгал	8,786,526.33	11,366,899.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,029,221.14	10,565,599.74
210204	Ажилгүйдлийн даатгал	1,757,305.19	2,808,480.10
210205	Эрүүл мэндийн даатгал	17,573,052.66	27,339,607.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,683,200.00	47,398,730.00
210301	Гэрэл, цахилгаан	5,231,501.00	3,685,873.00
210302	Түлш, халаалт	41,014,699.00	41,760,679.00
210303	Цэвэр, бохир ус	2,437,000.00	1,952,178.00
2104	Хангамж, бараа материалын зардал	57,252,256.00	72,057,517.00
210401	Бичиг хэрэг	17,745,256.00	26,624,648.00

210402	Тээвэр, шатахуун	20,314,450.00	24,598,662.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,980,400.00	12,480,137.00
210404	Ном, хэвлэл		- 210,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	599,600.00	1,400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,612,550.00	6,744,070.00
2105	Нормативт зардал	932,000.00	468,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	932,000.00	468,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,479,910.00	16,842,601.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,335,750.00	3,063,500.00
210604	Урсгал засвар	15,144,160.00	13,779,101.00
2107	Томилолт, зочны зардал	12,136,400.00	10,105,000.00
210702	Дотоод албан томилолт	12,136,400.00	10,105,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		- -
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,340,808.00	15,792,790.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,505,900.00	12,947,550.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	336,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,073,900.00	2,439,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	104,508.00	118,740.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	40,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	280,500.00	247,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,343,451.60	55,989,280.81
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,343,451.60	55,989,280.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,275,780.00	56,177,771.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,590,245.00	55,567,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,590,245.00	48,567,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	7,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,685,535.00	610,371.51
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,685,535.00	610,371.51
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>43,982,835.40</u>	<u>(232.45)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>43,982,835.40</u>	<u>(232.45)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,178,428,900.00	1,502,480,756.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	5,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	5,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	5,000,000.00
120009	Бусад орлого		5,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,178,428,900.00	1,497,480,756.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,178,428,900.00	1,496,340,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,178,428,900.00	1,496,340,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,139,856.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,139,856.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,170,190,400.00	1,501,028,256.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,170,190,400.00	1,501,028,256.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,137,914,620.00	1,444,850,484.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	872,001,719.00	1,136,685,280.00
210101	Үндсэн цалин	699,645,428.00	768,455,622.00
210102	Нэмэгдэл	126,089,201.00	308,196,059.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,218,397.00	27,919,822.00
210104	Урамшуулал	16,048,693.00	32,113,777.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,839,583.00	142,085,196.49
210201	Тэтгэврийн даатгал	81,693,477.68	96,618,299.81
210202	Тэтгэмжийн даатгал	8,786,526.33	11,366,899.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,029,221.14	10,565,599.74
210204	Ажилгүйдлийн даатгал	1,757,305.19	2,808,480.10
210205	Эрүүл мэндийн даатгал	17,573,052.66	20,725,917.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,683,200.00	47,398,730.00

210301	Гэрэл, цахилгаан	5,231,501.00	3,685,873.00
210302	Түлш, халаалт	41,014,699.00	41,760,679.00
210303	Цэвэр, бохир ус	2,437,000.00	1,952,178.00
2104	Хангамж, бараа материалын зардал	56,354,000.00	69,513,447.00
210401	Бичиг хэрэг	17,558,000.00	26,624,648.00
210402	Тээвэр, шатахуун	20,314,450.00	24,598,662.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,980,400.00	12,480,137.00
210404	Ном, хэвлэл		210,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	599,600.00	1,400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,901,550.00	4,200,000.00
2105	Нормативт зардал	800,000.00	626,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	626,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,758,910.00	17,644,041.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,819,250.00	4,324,940.00
210604	Урсгал засвар	14,939,660.00	13,319,101.00
2107	Томилолт, зочны зардал	12,136,400.00	10,105,000.00
210702	Дотоод албан томилолт	12,136,400.00	10,105,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,340,808.00	15,792,790.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,505,900.00	12,947,550.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	336,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,073,900.00	2,439,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	104,508.00	118,740.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	40,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	280,500.00	247,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		5,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,275,780.00	56,177,771.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,590,245.00	55,567,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,590,245.00	48,567,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	7,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,685,535.00	610,371.51
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,685,535.00	610,371.51
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	8,238,500.00	1,452,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,238,500.00	1,452,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,238,500.00	1,452,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,238,500.00	1,452,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,238,500.00	1,452,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(8,238,500.00)	(1,452,500.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	334,498,880.00	232,545,463.64	-225,017,619.77		342,026,723.87
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	334,498,880.00	232,545,463.64	-225,017,619.77	0.00	342,026,723.87
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			43,982,835.40		43,982,835.40
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	334,498,880.00	232,545,463.64	-181,034,784.37	0.00	386,009,559.27
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	334,498,880.00	232,545,463.64	-181,034,784.37	0.00	386,009,559.27
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	334,498,880.00	232,545,463.64	-181,034,784.37	0.00	386,009,559.27
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-232.45		-232.45
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	334,498,880.00	232,545,463.64	-181,035,016.82	0.00	386,009,326.82

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,496,340,900.00	1,495,730,528.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,496,340,900.00	1,495,730,528.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,445,773,500.00	1,445,163,128.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,136,685,300.00	1,136,685,280.00
210101	Үндсэн цалин	763,925,100.00	768,455,622.00
210102	Нэмэгдэл	316,015,500.00	308,196,059.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,484,000.00	27,919,822.00
210104	Урамшуулал	27,260,700.00	32,113,777.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	142,085,800.00	142,085,196.49
210201	Тэтгэврийн даатгал	96,618,300.00	96,618,299.81
210202	Тэтгэмжийн даатгал	11,366,900.00	11,366,899.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,093,500.00	10,565,599.74
210204	Ажилгүйдлийн даатгал	2,273,400.00	2,808,480.10
210205	Эрүүл мэндийн даатгал	22,733,700.00	20,725,917.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,400,000.00	47,398,730.00
210301	Гэрэл, цахилгаан	4,200,000.00	3,685,873.00
210302	Түлш, халаалт	40,700,000.00	41,760,679.00
210303	Цэвэр, бохир ус	2,500,000.00	1,952,178.00
2104	Хангамж, бараа материалын зардал	68,873,900.00	68,486,091.00
210401	Бичиг хэрэг	26,100,000.00	26,624,648.00
210402	Тээвэр, шатахуун	19,921,500.00	23,458,806.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,252,400.00	12,480,137.00

210404	Ном, хэвлэл	1,000,000.00	322,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	1,400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00	4,200,000.00
2105	Нормативт зардал	800,000.00	626,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	626,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,000,000.00	18,984,041.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	4,984,940.00
210604	Урсгал засвар	14,000,000.00	13,999,101.00
2107	Томилолт, зочны зардал	10,108,700.00	10,105,000.00
210702	Дотоод албан томилолт	10,108,700.00	10,105,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,819,800.00	15,792,790.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,950,000.00	12,947,550.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,439,000.00	2,439,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	136,400.00	118,740.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	40,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	254,400.00	247,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,567,400.00	50,567,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,567,400.00	50,567,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,567,400.00	48,567,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,496,340,900.00	1,495,730,528.49
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,496,340,900.00	1,495,730,528.49
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,496,340,900.00	1,495,730,528.49
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	5	5
610001	Төсвийн байгууллага	5	5
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	43	43
620001	Удирдах ажилтан	5	5
620002	Гүйцэтгэх ажилтан	33	33
620003	Үйлчлэх ажилтан	4	4
620004	Гэрээт ажилтан	1	1
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	43	43
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	18	18
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	12	12
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	12	12
650010	Гэрээт ажилтан	1	1

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,139,856.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,139,856.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,139,856.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,139,856.00
210402	Тээвэр, шатахуун	1,139,856.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,139,856.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,139,856.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,139,856.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн Тамгын газрын зорилго нь шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүхийг хүний нөөц, шүүгчийн хараат бус байдлыг хангаж хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шүүхийн санхүү, эдийн засгийн баталгааг хангах, мэдээллээр хангах чиг үүргийг тухайн шүүхэд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад оршино.

Үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд дараах ажлыг хийж хэрэгжүүлнэ.

- Шүүхийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангах;
- Шүүхийн хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд хяналт тавих;
- Шүүхэд ирүүлсэн хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, бүртгэх;
- Шүүхийн бичиг хэрэг, захидал харилцаа, шуудан, архивын үйл ажиллагааг зохион байгуулах;
- Шүүхийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг зохион байгуулж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээг авах;
- хэргийн эд мөрийн баримтыг хадгалах, зөөвөрлөх, холбогдох шийдвэрийг хэрэгжүүлэх;
- Тухайн шүүхийн шүүн таслах болон бусад ажиллагааны тоон мэдээлэл гаргах;
- Иргэн, хуулийн этгээдээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуульд заасны дагуу шийдвэрлэж, хариу өгөх;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн Тамгын газар нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэв.

Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дотоод аудитын албанаас тухайн оны 5 дугаар сард цахимаар хяналт шалгалт хийгдсэн байна. Шалгалтаар зөрчил дутагдал илрээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газар нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2020 онд баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг шинэчлэн батлах тухай журмыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шүүхийн Тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 0.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөгөөр/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Бараа материал	7565.6	8292.9	727.3

Үндсэн хөрөнгө	378443.9	377716.4	-727.6
<u>Нийт хөрөнгө</u>	<u>386009.6</u>	<u>386009.3</u>	-0.3
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	386009.6	386009.3	-0.3
<u>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</u>	<u>386009.6</u>	<u>386009.3</u>	-0.3

Мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөр дансанд өөрчлөлт гараагүй, өр төлбөргүй ажилласан байна.

Бараа материалын данс 0.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь сэлбэг хэрэгсэл, барилгын засварын материал худалдан авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 0.7 сая төгрөгөөр буурсан нь дээд газраас нийлүүлсэн 49.2 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжөөр нэмэгдэж, элэгдлийн зардал нэмэгдсэнтэй холбоотой буурсан байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 0.3 сая төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1627.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийн төслийг хянаж, төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 106.9 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 13.4 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 9.8 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 22.6 сая төгрөгөөр, нормативт зардал 0.4 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 8.5 сая төгрөгөөр, томилолт, зочны зардал 4.7 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 1.3 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 1.9 сая төгрөгөөр тус тус бууруулж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл.

Тайлант оны батлагдсан төсвийг 8.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1496.3 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1495.7 сая төгрөгийн санхүүжилт олгож, 0.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1495.7 сая төгрөг буюу 99.1 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1440.3	1439,7	0,6	99.9%
2	Зөвлөл , хороо, комиссын гишүүд	3.2	3.2		100%
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж	50.5	50.5	0	100%
4	Шинжээч, орчуулагч, хэлмэрчийн зардал	2.0	2.0	0	100%
	Дүн	1496,3	1495,7	0,6	99.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас хөрөнгийн үнэлгээний шинжээчийн зардал 1.1 сая төгрөгийг нэмэлт дансанд орлого авч, тээвэр шатахууны зардалд зарцуулсан байна

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн Тамгын газар нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Шүүхийн Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 40 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 1210.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 18.1 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус хэлтэс нь оны эцэст хэмнэсэн 0.6 сая төгрөгийг төвлөрүүлэн, батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаагаа явуулж, жилийн эцэст өр төлбөргүй ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан, алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнээс 1374.5 сая төгрөгийн 10 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээнээс 77.1 сая төгрөгийн 6 мэдээллийг оруулахаас, мэдээлбэл зохих бүх мэдээллийг цаг тухайд нь бүрэн мэдээлж ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудитын хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой хугацаа хоцроосон 11 мэдээлэлд зөвлөмж өгөгдсөнөөс биелэлтийг бүрэн хангаж ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн зарцуулалтыг түүвэрлэн шалгасан тул, гүйцэтгэлийн аудитаар цалингийн зардал болон бусад зардлуудыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

5.1 Төлбөрийн акт

Байхгүй.

5.2 Албан шаардлага

Байхгүй.

5.3 Зөвлөмж

Байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	

